



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/652

Хэрлэн сум

Хяналт шалгалтын ажил зохион  
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/282, “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/372 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэгдэж буй Өмнөдэлгэр, Батширээт сумдын ойн сан, самар бэлтгэж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад 8,000,000 (найман сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022  
оны 12 дугаар сарын 20-ны  
дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)
1	Томилолт	9 хүн 7 хоног	4,032,000
2	Шатахуун	А-92 - 290 л ДТ- 310 л Масло - 4 л	2,168,000
3	Аяны майхан (өвлийн -6 хүний)	1	1,800,000
Нийт зардал			8,000,000